



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/38 АУА-2018/82/СТА-ТШЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Өндөршил сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 4,713,624.00 /Дөрвөн сая долоон зуун арван гурван мянга зургаан зуун хорин дөрвөн/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Урсгал засвар, түлш халаалтын зардлаас 309,450.00 /гурван зуун есөн мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийг шатахуунд зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 03 сарын 14-ний өдрийн 55 тоот тушаалаар батлагдсан "Зардлын Эдийн засгийн ангилал"-ын Урсгал засвар /Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжид урсгал засвар хийхтэй холбогдон гарсан зардал, засвар үйлчилгээний материал авах, засвар үйлчилгээний ажлын хөлс зэргийг энэ ангилалд бүртгэнэ. Мөн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээтэй холбоотойгоор гарах зардлыг энэ ангилалд бүртгэнэ./, Түлш халаалт /Уурын болон дулааны халаалтад холбогдсон байгууллага үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх дулааны эрчим хүч болон халуун усны төлбөр, мөн түүнчлэн ердийн халаалтын зууханд хэрэглэх аргал, түлээ нүүрс, мод зэрэг түшинд гарсан зардлыг харуулна. Түлш бэлтгэхтэй холбоотойгоор гарах тээвэр шатахууны зардлыг энэ ангилалд бүртгэхгүй тээвэр шатахууны зардалд бүртгэнэ./ гэж заасныг зөрчсөн.

2. Хүүхдийн хоолны нормативыг дагаж мөрдөөгүй 126,823.00 /нэг зуун хорин зургаан мянга найман зуун хорин гурван/төгрөгийн зардлыг дутуу тооцож олгосон.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 4 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар батлагдсан "Цэцэрлэг сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэм"-д тогтоосон нормативыг баримтлаагүй.

3. Үндсэн хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн. 3,700,000.00 /гурван сая долоон зуун мянган/ төгрөг.

Энэ нь УСНББОУС-17 14.а, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журам"-ын 4.30-д Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө. /хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн байгууллага хүртэх магадлалтай/ заасныг зөрчсөн.

4. Бэлэн мөнгөөр гарсан 270,000.00 /хоёр зуун далан мянган/ төгрөгийн гүйлгээг бүртгэлд тусгахдаа анхан шатны баримтыг хөтлөөгүй, тайлан гаргаагүй.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, 13.4-т /Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна./, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.10-д /Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого зарлагын баримтыг бичнэ/, 5.3-д /Төсвийн байгууллага нь төлбөрийн картаар дамжуулан авсан жижиг мөнгөн сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг төлбөрийн картын дансны дэлгэрэнгүй хуулгын хамт хянуулан дараагийн ЖМС авах эрх эдэлнэ./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
2. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалтыг хийх;
3. Хөрөнгийн ангиллын зөрүүг арилгаж, зөв ангилж бүртгэх;
4. Бэлэн мөнгөөр гарсан гүйлгээнд анхан шатны баримтыг хөтөлж, тайлан гаргах;
5. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Өндөршил сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Д.Номин-Эрдэнэ, нягтлан бодогч Х.Үнэнтунгалаг нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**  **АУДИТОР** *Х. ӨЮУН-ЭРДЭНЭ* **ЭРХЛЭГЧ** *Д.НОМИН-ЭРДЭНЭ* **НЯГТЛАН БОДОГЧ** *Х. ҮНЭНТУНГАЛАГ*

**ЗӨВШӨӨРСӨН:**  **Д.НОМИН-ЭРДЭНЭ**  
**НЯГТЛАН БОДОГЧ** *Х. ҮНЭНТУНГАЛАГ*

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.